

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: УАГ-ГАГ/2020/09-ГА

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД
ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ БҮРЭН
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodoli@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Ахлах аудитор П.Содном
Утас: 70342716 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн товъёг.....	4
<u>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....</u>	5
БҮЛЭГ А. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй байна.....	6
А.1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....	6
А.1.1. Сонгуулийн ерөнхий хороо нь улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг хүн ам, нутаг дэвсгэр, байршлаар нь тооцож санхүүжилтийг хуваарилан ажиллажээ.....	6
А.1.2. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилж нийт 363268.8 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох сумдын дансанд шилжүүлэн ажиллажээ.....	6-7
А.2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн 368899.0 мянган төгрөгөөс 363268.8 мянган төгрөгийг сонгуулийн зардалд зарцуулж 5630.2 мянган төгрөгийн үлдэгдлийг холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллажээ.....	7
А.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан ч зарим сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд анхан шатны баримтын бүрдэлт дутуу, жолоочийн тооцооны замын хуудсыг үнэн зөв хөтлөөгүй, дутуу хөтөлсөн зөрчлүүд илэрлээ.....	7-8
А.2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнаж ажиллажээ.....	8-9
А.2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан уу? Санхүүжилт олгоогүй болно.....	9
А.2.4. Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллажээ.....	9
 ДҮГНЭЛТ.....	9-10
ЗӨВЛӨМЖ.....	
МЭДЭГДЭЛ.....	

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын их хурал
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ҮСХ	Үндэсний статистикийн хэлтэс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ШӨХТГ	Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сумдад хуваарилсан санхүүжилтийн дүн	
Хүснэгт 2	Нийт зардлын гүйцэтгэл	

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		
Зураг 2		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д аудит хийнэ.
Аудитын зорилт	Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан УИХ, Засгийн газар, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд: • УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Сонгуулийн Ерөнхий хороо, аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн хороод, УБЕГ, ҮСХ, ЦЕГ, ОБЕГ, ТЕГ, ТТХГ, ШӨХТГ байгууллагуудыг хамруулна.
Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	 Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа, П.Содном, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл ажлын 39 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	

БҮЛЭГ А. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй хэрэгжсэн байна.

А.1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

А.1.1 Сонгуулийн ерөнхий хороо нь улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг хүн ам, нутаг дэвсгэр, байршлаар нь тооцож санхүүжилтийг хуваарилан ажиллажээ.

Монгол улсын СЕХ нь төсвийн тухай хуулийн 6.4, 6.5, Монгол улсын УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн заалтуудыг тус тус баримтлан ажиллаж аймгийн хэмжээнд сонгуульд зарцуулагдах төсөв санхүүжилтийг хүн ам, нутаг дэвсгэрийн байршлаар нь, зардлыг 16 төрөлд ангилан аймгийн хэмжээнд нийт 368899.0 мянган төгрөгийг олгохоор төсөвлөсөн байна.

Үүнд: УИХ -ын сонгуулийг зохион байгуулахад шаардлагатай санал авах байрыг тохижуулах, сонгуулийн хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, гарын авлага хүргэх, сургалт, сурталчилгаа, онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал, ажиллагсдын урамшуулал, аймгийн сонгуулийн хороо болон хэсгийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолт, цалин урамшуулал, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн тусгажээ.

Монгол улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтаар аймгийн сонгуулийн хороонд ажиллах дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, мөн 16 сумын хэсгийн хороонд ажиллах дарга гишүүдийг томилох тухай тогтоол гаргахдаа Монгол улсын УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 16.1¹ гэсэн заалтыг баримтлан ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 68 хэсгийн хороо байгуулж аймаг, сумдын сонгуулийн хороонд 89 гишүүд, хэсгийн хороонд ажиллах ажилчдын тоог 492 хүнээр тооцоолон судалгааг хүргүүлжээ.

А.1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилж нийт 363268.8 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох сумдын дансанд шилжүүлэн ажиллажээ.

СЕХ-ноос аймаг нийслэлийн сонгуулийн хорооны дарга нарт 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 3/60 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралтаар төсвийн зарцуулалтын тухай тайлбар, сум дүүргийн хорооны сонгуулийн дансны жагсаалтыг хавсарган хүргүүлж ажилласан байна.

СЕХ-ны 5 удаагийн санхүүжилтээр нийт 363268.8 мянган төгрөгөөр санхүүжилтийг 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 3/281 тоот албан бичгээр төсвийн зарцуулалтын тухай тайлбар, цаашид анхаарч ажиллах тухай чиглэл, үүрэг даалгаврыг хавсралтаар тус тус хүргүүлэн ажиллажээ.

Аймгийн сонгуулийн хороо нь 16 сумын хэмжээнд сонгуулийн хороонд ажиллах ажлын хэсэг ажиллагсдын тоо, нутаг дэвсгэр, км-ын хэмжээ зэргийг харгалзан үзэж зардал тус бүрээр нийт 368899.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилж, сумдын сонгуулийн хороонд олгосон байна.

Сумдад хуваарилсан санхүүжилтийн дүнг хүснэгтээр харуулбал: /төгрөгөөр/

№	Сумдын нэрс	Санхүүжилтийн дүн	Дансны дугаар
---	-------------	-------------------	---------------

¹ "Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ байна."

1	Булган аймаг	28588550	100040022001
2	Баян-Агт	24260000	100040122001
3	Баяннуур	8367000	100041522001
4	Бугат	12098600	100040222001
5	Булган	26058000	100041422001
6	Бүрэгхангай	19754000	100040322001
7	Гурванбулаг	28062000	100040422001
8	Дашинчилэн	19907000	100040522001
9	Могод	24100000	100040622001
10	Орхон	23874000	100040722001
11	Рашаант	15928000	100041622001
12	Сайхан	30179000	100040822001
13	Сэлэнгэ	20765800	100040922001
14	Тэшиг	25597900	100041022001
15	Хангал	11444400	100041122001
16	Хишиг-Өндөр	23970000	100041222001
17	Хутаг-Өндөр	25944750	100041322001
Нийт дүн		368899000	

А.2 УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн 368899.0 мянган төгрөгөөс 363268.8 мянган төгрөгийг сонгуулийн зардалд зарцуулж 5630.2 мянган төгрөгийн үлдэгдлийг холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллажээ.

А.2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан ч зарим сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд анхан шатны баримтын бүрдэлт дутуу, жолоочийн тооцооны замын хуудсыг үнэн зөв хөтлөөгүй, дутуу хөтөлсөн зөрчлүүд илэрлээ.

Аймгийн хэмжээнд УИХ-ын 2020 оны сонгуулийн зардлыг улсын төсвөөс 368899.0 мянган төгрөгөөр төсөвлөн зардал тус бүрээр баталсны дагуу аймгийн сонгуулийн хороо болон 16 сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодод шаардагдах төсвийг Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журмын дагуу хуваарилан ажиллаж, СЕХ-ноос өгсөн тайлбар зөвлөмжийн дагуу сумдын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт сонгуулийн зардлыг үр дүнтэй арвилан хэмнэлттэй, НББ-ийн тухай хууль, холбогдох хууль журмын дагуу зарцуулах талаар сургалт зохион байгуулан ажилласан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтын бүрдэлтэд тулгуурлан шалгахад зарим сумдын сонгуулийн хороод 950.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу, 991.0 мянган төгрөгийн жолоочийн тооцооны замын хуудсыг үнэн зөв бөглөөгүй, нормын дагуу шатахуун олгоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй дутуу зэрэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал: Тэшиг сумын сонгуулийн хороо нь 750.0 мянган төгрөгийн ярианы төлбөрийн, Сэлэнгэ сумын сонгуулийн хороо нь 150.0 мянган төгрөгийн томилолтын хуудас дутуу бөглөсөн, Баяннуур сумын сонгуулийн хороо нь 50.0 мянган төгрөгийн материалын зарлагыг шатахуун авснаар бүрдүүлсэн нийт 950.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу зөрчил илэрлээ.

Мөн Сэлэнгэ сумын сонгуулийн хороо нь 157.2 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг дутуу хөтөлсөн, Баяннуур сумын сонгуулийн хороо нь шатахуун зарцуулалтыг автомашины нормоор олгоогүй, прусс-20 маркын машиныг 100 км-т 20 л шатахуун зарцуулснаар жолоочийн тооцооны

замын хуудсыг илүү олгосноор хөтөлсөн, Сайхан сумын сонгуулийн хороо нь шатахууны зардал олгохдоо машин бүрд 100км 15-20 л шатахуунаар тооцон олгосон, 3 авто машины нормыг тооцон үзэхэд 2215 км, зарцуулсан шатахууны зөрүү 203.6 л буюу 297.2 мянган төгрөгийг үргүй зардалд зарцуулсан, Могод сумын сонгуулийн хороо нь 10 автомашинд 104 л шатахуун зарцуулснаар хөтөлж 145.8 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон, Сайхан сумын сонгуулийн хороо нь зарим жолоочийн тооцооны замын хуудасны хөтлөлт дутуу, бүрэн хөтлөөгүй 172.3 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлт дутуу, Рашаант, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Сайхан сумдын сонгуулийн хороод нь жолооч нартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй зөрчлүүд илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 13.6.², 13.7.³, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм"-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид НББ-ийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг нормыг баримтлан ажиллах шаардлагатай байна.

А.2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнаж ажиллажээ.

СЕХ-оос улсын төсвөөс аймаг, сумдын сонгуулийн зардалд 368899.0 мянган төгрөг баталснаас гүйцэтгэлээр 363268.8 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 5630.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажиллажээ.

Аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлын гүйцэтгэлийг аймгийн сонгуулийн хороо нэгтгэн авч гүйцэтгэлийн тайлан, мэдээг тайлагнаж СЕХ-нд хүргүүлэн ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	мян/төг
					Гүйцэтгэлийн хувь
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх	250.0	242.5	7.5	0
2	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	15218.0	15107.5	110.5	5
3	Аймаг, Нийслэл, сум дүүрэг, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	11520.0	11359.3	160.7	4
4	Аймаг, Нийслэл, сум дүүрэг, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	13600.0	13215.4	384.6	4
5	Аймаг, Нийслэл, сум дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	41350.0	39881.1	1468.8	11
6	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	14960.0	14807.8	152.1	4
7	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	14896.0	13991.0	904.9	4
8	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	650.0	650.0	-	1

² Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

³ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах

9	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	2380.0	2185.4	194.6	1
10	Сурталчилгааны зардал	5000.0	5000.0	-	2
11	Саналын хуудас устгах зардал	358.0	358.0	-	0
12	Томилолтын зардал	4982.0	4775.8	206.2	2
13	Болзошгүй зардал	3000.0	1347.3	1652.7	1
14	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	206900.0	206900.0	-	57
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	31250.0	31250.0	-	9
16	Мэдээ дамжуулах унааны зардал	2585.0	2197.6	387.4	1
НИЙТ ДҮН		368899.0	363268.8	5630.2	99

Дээрх хүснэгтээс зардлын гүйцэтгэлийг үзэхэд 57 хувийг сонгуулийн ажилтны урамшуулал, хоолны зардал, 11 хувийг унааны зардал, 9 хувийг мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал хоолны зардлууд тус тус ихээхэн хувийг эзэлж байна.

А.2.3 Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан уу? Санхүүжилт олгоогүй болно.

А.2.4 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллажээ.

Монгол улсын СЕХ нь 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байгуулах тухай 20 дугаар тогтоолын дагуу аймгийн сонгуулийн хороо нь хуралдаанаараа ажлын төлөвлөгөө болон гишүүдийн ажил, үүргийн хуваарийг сонгуулийн хорооны даргын 01 дүгээр захирамжаар батлуулан ажиллаж аймгийн сонгуулийн хорооноос 5 удаагийн санхүүжилт олголт бүрд, мөн 1 удаагийн сургалтаар сумдын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулж уг сургалтаар сонгуулийн зардлыг зарцуулах тухай заавар зөвлөгөөг өгч арга зүйгээр ханган ажилласан байна.

Мөн сумдын сонгуулийн хорооны нягтлан бодогч нараар сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг гаргуулан авч анхан шатны баримттай нь тулган баталгаажуулж архивын нэгж болгон баримтжуулан ажилласан нь сонгуулийн зардлын гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Аудитаар 1941.0 мянган төгрөгийн зөрчил илэрч тухайн зөрчлийг дахин гаргахгүй ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Монгол улсын СЕХ нь төсвийн тухай хуулийн 6.4, 6.5, Монгол улсын УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн заалтуудыг тус тус баримтлан аймгийн сонгуулийн хороонд нийт 368899.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.
- Аймгийн сонгуулийн хороо нь санхүүжилтийг хуваарилахдаа 16 сумын хэмжээнд сонгуулийн хороонд ажиллах ажлын хэсэг ажиллагсдын тоо, нутаг дэвсгэр, км-ын хэмжээ зэргийг харгалзан үзэж санхүүжилтийг хуваарилсан байна.
- НББ-ийн тухай хууль, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалаар баталсан

"Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм"-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Зардлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж өмнө нь илэрч байсан алдаа зөрчлүүд багассан нь хөрөнгийн зарцуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэж байна.

Цаашид алдаа зөрчилгүй, холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА

АУДИТОР

Б.ЭНХТӨР